

2011-2012 ОНЫ ТОМУУГИЙН УЛИРАЛД ТХТН-ҮҮДИЙН  
ҮЙЛ АЖИЛЛАГААГ ҮНЭЛЭХ ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТҮҮД

Р.Туул, Б.Дармаа, Б.Ганцож, П.Нямдаваа  
Монгол-АНУ-ын “Томуугийн тандалтын сүлжээг бэхжүүлэн хөгжүүлэх” төслийн баг

ТХТН-үүдийн 2011/2012 оны томуугийн тандалтын улиралын бүрийн үйл ажиллагааг дүгнэхдээ мэдээ ирүүлсэн хувь, илрүүлсэн вирүсийн тоо, сорьц ирүүлсэн хувь, вирүс илрүүлсэн хувь, өмнөх оны

дүн, аудио хуралд оролцсон байдал гэсэн шалгуур үзүүлэлтүүдээр [Хүснэгт] 1 0-5 оноо өгч, онооны дунджийг гаргана. Бүтэн жилийн үнэлгээг хийхдээ 4 улирал тус бүрт авсан онооны дунджийг гаргана.

Хүснэгт 1

Үнэлгээний хамралт

	Шалгуур	I зэрэглэл	II зэрэглэл	III зэрэглэл
1	Мэдээ өгөлт			
2	Аудио хуралд оролцсон байдал			
3	Өмнөх оны үнэлгээ			
4	Сорьц ирүүлсэн хувь			
5	Вирүсийн тоо			*
6	Вирүс илрэлтийн хувь			*

\* сорьц ирүүлээд вирүс илэрсэн тохиолдолд энэ шалгуурыг ашиглана

Оноо өгөх журам:

1. Мэдээ өгөлт, мэдээг хугацаанд нь өгвөл - 5 оноо

Хоорч өгвөл - 2,5 оноо улиралын эцэст мэдээ өгөлтийн оноог:

$5x$  “Хугацаандаа өгсөн тоо” +  $2.5x$  “Хоорч өгсөн тоо” / өгвөл зохих мэдээний тоо гэсэн томъёогоор бодож гаргана.


2. Аудио хуралд оролсон байдал оноог:

$5x$  “Хугацаандаа орсон тоо” +  $2.5x$  “Хоорч өгсөн тоо” / орвол зохих тоо гэсэн томъёогоор бодож гаргана.

3. Бүртгэгдсэн өвчлөлийн 40%-60%-аас сорьц авсан байвал хамгийн оновчтой байх алгоритмаар сорьц ирүүлсэн хувийг:


Ирүүлсэн сорьцтой тоо / өвчлөх х 100%

томъёогоор бодож олно. Гарсан хувиар нь доорх оноог өгнө [Зураг 1]



Зураг 1 Сорьц авалтын оновчтой хувийн график

4. Вирусийн тоо, Вирус илрэлтийн хувь  
Энэ 2 үзүүлэлтийн оноог өгөхдөө ижилхэн аргыг хэрэглэв.




**max** – хамгийн их утга, **min** – хамгийн бага утга,  
**d** – завсарын урт,  
 $d = (\max - \min) / 5$

[min, min+d[	1 оноо
[min+d, min+2d[	2 оноо
[min+2d, min+3d[	3 оноо
[min+3d, min+4d[	4 оноо
[min+4d, max]	5 оноо

5. Эзэлсэн байр ахисан байдлыг жилийн дүн гаргахад ашиглана.

Улирал бүр байр ахиж байсан бол нэмэлт оноо өгнө. Үүнд: Өсөлтийн коэффициентын таигенсийг ашиглана Зураг 2.

Энд: Өсөлтийн өнцгийн коэффициент –  $\text{tg}(\alpha)$



Зураг 2. Үйл ажиллагааны ахицыг тоолох график

Ерөнхий зарчим баримтлана хүснэгт 2

Хүснэгт 2

ТХТН-үүдийн үйл ажиллагааны үзүүлэлтийн зэрэглэл

Эмнэлэг	байр	оноо
Өрхийн эмнэлэг	I	3.50-5.00
	II	2.50-3.49
	III	2.10-2.49
Нэгдсэн эмнэлэг	I	4.00-5.00
	II	3.00-3.99
	III	2.50-2.99
Лаввлагаа төв	I	3.50-5.00
	II	2.50-3.49
	III	2.10-2.49

\* \* \*